



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2018 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 01

Өлгий

**Угаарын хийн хордлогоос сэргийлэх ажлыг
эрчимжүүлэх тухай**

Аймгийн хэмжээнд 2016 онд 12 хүн угаарын хордлогод өртөж 1 хүн нас барсан, 2017 онд 25 хүн өртөж, 2 хүн нас барсан 2018 он гарснаас хойш угаарын хийн нийт 5 тохиолдол бүртгэгдэж, 34 хүн өртөн 3 хүн нас барсан байна. Сүүлийн жилүүдийн тоо баримтаас угаарын хийн хордлогод өртөх тохиолдол өмнөх жилүүдээс нэмэгдэж байгаа нь харагдаж байна. 2018 онд бүртгэгдсэн угаарын хийн хордлогыг багаар нь авч үзвэл 13,6,4,3,12 багуудын иргэд өртсөн байна.

Иймд угаарын хийн хордлогын эрсдэлийг бууруулахад дараах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг холбогдох газар, хэлтэс, байгууллагын дарга нарт ДААЛГАХ нь:

Мэргэжлийн хяналтын газарт:

- 1.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд заагдсан ахуйн зуух пийшингийн стандарт, хэрэглээний аюулгүй байдалд үнэлгээг яаралтай хийх
- 2.Эрсдэлт бүхий галлагаат пийшингийн тоон судалгаа, зураглалыг яаралтай гаргах
- 3.Бүх 13 багийн нутаг дэвсгэрт угаарын хийн хордлогын эрсдэлийг харуулсан, түүнээс урьдчилан сэргийлэх талаар илтгэсэн зурагт самбарыг ард иргэдэд харагдахуйц газар байрлуулах
- 4.Нүүрсний Хотгорын уурхайтай хамтран нүүрснээс дээж авч шинжилгээг холбогдох лабораторт хийлгэх, дүгнэлт гаргуулах
- 5.Угаарын хийн хордлогын аюул эрсдлийг ойлгуулах зорилгоор хүн амд чиглэсэн ухуулга сурталчилгааны үйл ажиллагааг 2019 оны 2 дугаар улирал хүртэл төлөвлөгөө гарган батлуулан тасралтгүй явуулах
- 6.Аюулгүй байдлаа хангаагүй галлагаат пийшингийн тоон судалгаа хийх, зураглал гарган зөрчлийг арилгуулах.

Онцгой байдлын газарт:

- 1.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд заагдсан ахуйн зуух пийшингийн стандарт,хэрэглээний аюулгүй байдалд үнэлгээг яаралтай хийх
- 2.Эрсдэлт бүхий галлагаат пийшингийн тоон судалгаа, зураглал яаралтай гаргах

00000000?

3.Стандартын бус, аюулгүй байдлыг бүрэн хангаагүй, ан цав гарсан угаарын хийн эрсдэл бүхий галлагаат болон ханан пийшинг харуулсан богино хэмжээний видео, шторк боловсруулж орон нутгийн телевизээр олон давтамжтай харуулах

4.Угаарын хийн хордлогын аюул эрсдэлийг ойлгуулах зорилгоор хүн амд чиглэсэн ухуулга сурталчилгааны үйл ажиллагааг 2019 оны 2 дугаар улирал хүртэл төлөвлөгөө гарган батлуулан тасралтгүй явуулах

5.Аюулгүй байдлаа хангаагүй галлагаат пийшингийн тоон судалгаа хийх, зураглал гарган зөрчлийг арилгуулах.

Эрүүл мэндийн газарт:

1.Угаарын хийн хордлого гарахаас сэргийлэх хүн амын мэдлэг, хандлагыг өөрчлөх, сургалт сурталчилгааг төлөвлөгөөтэй зохион байгуулах

2.Угаарын хийн хордлогын аюул эрсдлийг ойлгуулах зорилгоор хүн амд чиглэсэн ухуулга сурталчилгааны үйл ажиллагааг 2019 оны 2 дугаар улирал хүртэл төлөвлөгөө гарган батлуулан тасралтгүй явуулах

3.Өрхийн ЭМТ-ээс тархвар зүйн баг томилон ажиллуулах, угаарын хийнд өртөж болзошгүй хүн ам, өрх, эрсдэлт бүлгийг тодорхойлох ажлыг зохион байгуулж, хийлгэх

4.Орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэнг идэвхтэй ажиллуулах

5.Ахуйн пийшингийн стандарт,хэрэглээний аюулгүй байдалд үнэлгээ хийх.

6.Угаарын хийн хордлогоос сэргийлэх инфографик мэдээллүүдийг казах хэл дээр бэлтгэж хэвлүүлэн түгээх.

Стандарт хэмжил зүйн хэлтэст:

1.Ахуйн хэрэглээний зуухны Монгол улсын стандарт /ТЕШ MNS 5216-2016/-ыг баримтлан барьж буй зуух пийшингийн үзүүлбэрийг ард иргэдэд ойлгомжтой байдлаар зураг дүрсээр илэрхийлсэн шторк, видео бичлэгийг боловсруулан орон нутгийн телевизээр олон давтамжтай хүргэх

2.Угаарын хийн хордлогын аюул эрсдэлийг ойлгуулах зорилгоор хүн амд чиглэсэн ухуулга сурталчилгааны үйл ажиллагааг 2019 оны 2 дугаар улирал хүртэл төлөвлөгөө гарган батлуулан тасралтгүй явуулах

3.Пийшин хийдэг хүмүүсийн судалгааг гаргаж, ахуйн хэрэглээний зуухны Монгол улсын стандарт /ТЕШ MNS 5216-2016/-ыг танилцуулах, сургалт хийх

4.Нүүрсний Хотгорын уурхайтай хамтран нүүрснээс дээж авч шинжилгээг холбогдох лабораторт хийлгэж, дүгнэлт гаргуулах

Өлгий сумын Засаг даргад:

1.Багийн дарга, нийгмийн ажилтнуудын дунд угаарын хийн хордлогын эрсдэлээс сэргийлэх аяныг өрнүүлж 2019 оны эхээр эрсдэл бууруулсан багийн дарга, ажилтнуудыг шалгаруулан шагнал урамшуулал олгох

2.Иргэдтэй хамгийн ойр байдаг багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрсдэлийн хор уршгийг ойлгуулан таниулах “хөршийн холбоо”, “ахмадын зөвлөл”, “сайн дурын идэвхтэн” зэрэг үйл ажиллагааг өрнүүлэх, муу ажиллагаатай багийн үйл ажиллагаанд үнэлэлт өгч, эрх зүйн холбогдох арга хэмжээг авах

3.Багийн Засаг дарга нар мэргэжлийн байгууллагуудтай хамтран багийн иргэдэд сургалт хийх

4.Багийн Засаг дарга, нийгмийн ажилтнууд, ӨЭМТ-тэй хамтран угаарын хийн хордлогын аюул эрсдэлийг ойлгуулах зорилгоор хүн амд чиглэсэн ухуулга сурталчилгааны үйл ажиллагааг 2019 оны 2 дугаар улирал хүртэл төлөвлөгөө гарган батлуулан тасралтгүй явуулах

Боловсрол, соёл, урлагийн газарт:

1.Хүйтний улирал эхэлж галлагаат пийшингийн засвар үйлчилгээ хийх үед сургуулийн сурагчдын дунд “Танай пийшин эрсдэлтэй үгүй эсэх”-ийн талаар асуумж судалгаа явуулж үр дүнг нь хүүхдүүдэд танилцуулан тэднээр дамжуулан эцэг эх, ар гэрийнхний сэрэмж, хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

Холбогдох бүх байгууллагууд энэхүү албан даалгаврыг хэрэгжүүлэн ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг сар бүрийн 15,30-ны өдрүүдэд ЗДТГ-ын НБХ-т ирүүлж байх.

Аймгийн Засаг даргын А/68 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж,албан даалгаврын тайлан мэдээг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлж байх.

